



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/28

Амардалай

Худалдаа үйлчилгээний газрын цагийн хуваарьт  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.7, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Суманд худалдаа үйлчилгээ явуулдаг аж ахуй нэгжүүд сар бүрийн 15,25-ний өдрүүдэд архи, согтууруулах ундааг худалдан борлуулахыг хориглож, бусад өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг аж ахуй нэгж байгууллагын ажиллах цагийн хуваарийг 08:00-21:00 цагийн хооронд шилжүүлсүгэй.

2.Ард иргэдэд үйлчлэх тав тухтай орчныг бүрдүүлж, хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг тогтмол ханган өөрийн байгууллагын гадна, дотно орчныг сайжруулж, нийтийг хамарсан их цэвэрлэгээний үед худалдаа үйлчилгээ явуулахыг түр хугацаагаар зогсоож, өөрийн аж ахуй нэгжийн ойр орчмын 50 хүртэлх талбайг цэвэрлэж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аж ахуй нэгж, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Сумын хэсгийн төлөөлөгч (Б.Азжаргал), хэсгийн цагдаа (Э.Лүндээжанцан), Хүнс, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн (Б.Сармандах) нарт даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 11 дүгээр сарын 17-ний өдрийн А/127 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

192401053